



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/49


Улаанбаатар хот

Хоол, унааны зардлыг шинэчлэн
тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын хавсралтын 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдад олгох хоол, нийтийн тээврийн унааны зардлын хэмжээг ажлын нэг өдөрт 35,000 /гучин таван мянган/ төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.
2. Шинэчлэн тогтоосон хоол, унааны зардлыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.
- 3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003295